

ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ
ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠳᠢᠲᠤᠨ ᠭᠠᠰᠠᠷ

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



АЙМГИЙН 2025 ОНЫ НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ГАА-2026/001-НА-СТА-ТЕЗ

2026 он



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026. 04. 20

№

157

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг, хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлүүд бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 1,214.9 сая төгрөгийн 32 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй, хүлээж аваагүй, он дамжсан, тус сангийн эх үүсвэрээр тайлант онд бэлтгэсэн 338.6 сая төгрөгийн өвс, тэжээлийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, харилцагчаар бүртгээгүй;
- Сум дундын Хөдөө аж ахуйн бааз байгуулах зорилгоор худалдан авсан 682.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланд борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн хөрөнгөөр 2021 оноос хойш бүртгэсэн нь санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант оны санхүүгийн үр дүн, өмч хөрөнгийн бүртгэлтэй холбоотой дараах асуудлыг онцолж байна. Тухайлбал:

822511000499

- Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 31,309.1 сая төгрөгөөр буюу 21.2 хувиар өсөхөд мөнгөн хөрөнгө 13,820.1 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгө 18,116.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн 4,841.6 сая төгрөгийн Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгыг Тайшир, Баян-Уул сумдад хүлээн авч бүртгэлд тусгасан,
- Богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 2.5 дахин буюу 2,610.7 сая төгрөгөөр өссөн байна.

Аудитын гол асуудал

Алтай орон сууц корпорац ААТҮГ нь 5,608.5 сая төгрөгийн, Ундарга-Алтай ААТҮГ 1,094.0 сая төгрөгийн, нийт 6,702.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн, урт хугацаат зээлийн үлдэгдэлтэй байгаа нь хүү, алданги нэмэгдэх, төлбөрийн чадвар буурах зэрэг үр дагавар бий болохоор байна.

Тайлант онд харьяа байгууллагууд тогтмол зардлын 4,311.5 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлтэй өмнөх оноос 2.5 дахин өссөн нь төсөв, санхүүгийн үйл ажиллагаа доголдох эрсдэл үүсэхээр байна.

Иргэд, аж ахуйн нэгжүүдийн хөдөлмөр эрхлэлт, бизнесийг дэмжих зорилгоор Хоршоо хөгжүүлэх сан, Мал хамгаалах сан, Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангуудаас олгосон 1,202.7 сая төгрөгийн зээл, зээлийн хүү төлөгдөөгүй, хугацаа хэтэрсэн нь эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр дутагдах, тусгай сангуудын үйл ажиллагааг хэвийн явуулахад хүндрэл үүсэж байна.

Төсөвт тодотгол хийхдээ төсвийн орлого, зардлыг нийт 12,829.7 сая төгрөгөөр бууруулж баталсан бөгөөд Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгийг 6,464.3 сая төгрөгөөр, сумдад олгох татаас шилжүүлгийг 3,565.1 сая төгрөгөөр, Засаг дарга ерөнхий дансны зардлын төсвийг 2,689.7 сая төгрөгөөр, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны төсвийг 110.6 сая төгрөгөөр тус тус хасах тодотгол хийсэн байна.

Засаг дарга ерөнхий данснаас 2,073.1 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, сургалт, судалгаа болон албан томилолт, иргэн, төрийн бус байгууллагын дэмжлэг, бэлэг, шагнал, урамшуулал зэрэгт зориулалт бусаар зарцуулсан бөгөөд өмнөх зөрчлийг давтан гаргасан.

Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах, дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 800.0 сая төгрөгийг буцалтгүй тусламж, дэмжлэг хэлбэрээр аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Ерөнхий сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан батламжид тусгасан 7 арга хэмжээг 97.5 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнасан байна.

Сумдын Засаг дарга нартай байгуулсан гэрээний биелэлтийг дүгнээгүй, Засаг даргын Тамгын газруудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт дунджаар 85.0 хувьтай, өргөдөл гомдлын шийдвэрлэлт 83.5 хувьтай, албан бичгийн шийдвэрлэлт 54.0 хувьтай, ил тод байдлын шалгуур 33.5 хувьтай байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Говь-Алтай аймгийн Засаг дарга Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын

секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/12

Алтай хот

Санхүүгийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны “Эрх шилжүүлэх тухай” А/175 дугаар тушаалын гуравдугаар хавсралтын 1 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар өгсөн шийдвэрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

3. Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасан хугацаанд, шийдвэрийн хэрэгжилтийг заасан хугацаанд ирүүлэхийг Говь-Алтай аймаг Засаг дарга (Г.Чинбат)-д зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (Д.Цэрэнханд)-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Эрдэнэчимэг)-т үүрэг болгосугай.



822501000024

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын
 газрын дарга, тэргүүлэх аудиторын 20.26
 оны 04 дугаар сарын 20-ны өдрийн А/12
 дугаар тушаалын хавсралт

Аудитаар өгсөн шийдвэрийн жагсаалт

д/д	Хариуцагч	Шийдвэрийн			Зөрчлийн утга	Зөрчлийн дүн (мян.төг)
		Төрөл	Огноо	Дугаар		
1	Говь-Алтай аймгийн Засаг дарга	Төлбөрийн акт	2026.04.20	01/71	Техник хяналтын дансанд 5 дээш жил насжилттай өр төлбөрийг барагдуулаагүй	25,312.2
2	Говь-Алтай аймгийн Засаг дарга	Албан шаардлага	2026.04.20	01/100	Харъяа байгууллагын аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах	-
3	Говь-Алтай аймгийн Засаг дарга	Албан шаардлага	2026.04.20	02/100	Он дамжсан 32 төсөл арга хэмжээний ажлыг дуусаагүй, хүлээн аваагүй байна.	1,214,946.9
Нийт дүн						1,240,259.1

АГУУЛГА	
Тайлан бэлтгэсэн:	Хүснэгтийн тайлбар..... 2
Дарга, Тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа	1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ..... 3
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг	2. АУДИТ ХИЙСЭН 2025 ОНЫ НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН 3
Ахлах аудитор: Д.Цэрэнханд	2.1 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН.....3
Аудитор: Э.Сүнжидмаа	2.2 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН.....3
Н.Гэрэлмаа	3. АУДИТЫН ТАЙЛАН 6
	3.1 АУДИТЫН ТАЛААРХ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ 6
	3.1.1 Аудит хийсэн үндэслэл.....6
	3.1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ6
	3.1.3 Аудитын арга зүй 6
	3.1.4 Материаллаг байдлын түвшин6
	3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ ... 6
	3.2.1 Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж..... 7
	3.2.2 Санхүүгийн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн 7
	3.3 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААР 7
	3.3.1 Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан 7
	3.3.2 Нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 8
	3.3.3 Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 8
	3.3.4 Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан 8
	4. АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 8
	4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ..... 8
	4.2 АВЛАГА 9
2026 оны 04 дүгээр сар	4.3 УРЬДЧИЛГАА..... 12
	4.4 БАРАА МАТЕРИАЛ..... 12
	4.5 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ 13
	4.6 ҮНДСЭН ХӨРӨНГӨ 14
	4.7 ӨР ТӨЛБӨР 14
	4.8 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО..... 15
	4.9 ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ БОЛОН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧДЫН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ..... 15
Уг тайланг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын цахим хуудаснаас үзнэ үү: www.audit.mn	Дүгнэлт гаргасан байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудит 16
	Түүвэрт хамруулсан байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудит..... 16
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70483413 дугаар утсаар харилцана уу.	4.10 НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ, ЗАЛРУУЛГА 17
	4.11 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ 18
	4.12 ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА..... 18
	5. АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ..... 19
	5.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ 19
	5.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ 19
ХАЯГ: Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Жинст баг Хөгжил хороолол 1402	

Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБООУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БОГ	Байгаль орчны газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖДҮДС	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МХС	Мал хамгаалах сан
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НДШ	Нийгмийн даатгалын шийтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит Төсвийн үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

Хүснэгтийн тайлбар

- Хүснэгт 1. Санхүүгийн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн
Хүснэгт 2. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч
Хүснэгт 3. Мөнгөн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр
Хүснэгт 4. Авлага дансны ангилал, байгууллагын төрлөөр
Хүснэгт 5. Урьдчилгаа данс байгууллагын төрлөөр
Хүснэгт 6. Бараа материал данс байгууллагын төрлөөр
Хүснэгт 7. Нөөцийн бараа данс байгууллагын төрлөөр
Хүснэгт 8. Бусад эргэлтийн хөрөнгө данс байгууллагын төрлөөр
Хүснэгт 9. Үндсэн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр
Хүснэгт 10. Нийт өр, төлбөр дансны ангилал, байгууллагын төрлөөр
Хүснэгт 11. Засгийн газрын хувь оролцоо
Хүснэгт 12. Өмнөх санхүүгийн тайлангаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

2. АУДИТ ХИЙСЭН 2025 ОНЫ НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөг)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	42,662,599.2	55,855,009.2
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	13,051,117.4	26,871,243.2
3	АВЛАГА	12,967,210.0	12,521,219.3
4	УРЬДЧИЛГАА	168,799.9	165,473.1
5	БАРАА МАТЕРИАЛ	5,904,442.5	6,406,121.6
6	НӨӨЦИЙН БАРАА	558,496.9	625,702.1
7	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10,012,532.4	9,265,249.9
8	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	105,229,640.2	123,346,355.2
9	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	105,229,640.2	123,346,355.2
10	Биет хөрөнгө	82,845,288.8	100,472,685.9
11	Биет бус хөрөнгө	22,384,351.4	22,873,669.2
12	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	147,892,239.3	179,201,364.5
13	НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,461,488.0	17,426,545.8
14	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,057,070.6	7,665,967.6
15	Өглөг	4,705,319.6	7,006,952.6
16	Урьдчилж орсон орлого	1,351,751.0	659,015.1
17	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,404,417.4	9,760,578.2
18	Урт хугацаат зээл	9,404,417.4	9,760,578.2
19	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	132,430,751.3	161,774,818.6
20	Засгийн газрын хувь оролцоо	132,430,751.3	161,774,818.6
21	Засгийн газрын оруулсан капитал	17,741,471.2	17,738,825.1
22	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	14,915,809.6	14,915,809.6
23	Хуримтлагдсан үр дүн	92,871,966.9	122,241,329.5
24	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,901,503.5	6,878,854.3
25	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	147,892,239.3	179,201,364.5

2.2 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөг)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	94,631,017.7	117,432,088.6
2	ТАТВАРЫН ОРЛОГО	32,928,667.1	45,814,836.1
3	Орлогын албан татвар	26,784,801.8	38,289,677.7
4	Хувь хүний орлогын албан татвар	22,467,541.3	26,213,799.3
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(959,323.0)	(1,306,128.9)
6	ААН-ын орлогын албан татвар	5,276,583.4	13,382,007.3
7	Хөрөнгийн албан татвар	3,493,646.7	2,997,850.3
8	Бусад татвар, төлбөр, хураамж	2,650,218.7	4,527,308.2
9	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,437,645.7	71,617,252.6
10	Хөрөнгийн орлого	294,140.5	76,139.2
11	Тусламжийн орлого	-	2,131,597.8
12	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,264,704.9	-

13	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	68,828,284.9	77,697,241.7
14	УРСГАЛ ЗАРДАЛ	68,828,284.9	74,862,785.1
15	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	66,676,405.3	73,540,195.0
16	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	21,017,735.8	24,505,461.8
17	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,772,703.1	3,504,889.2
18	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,218,843.3	18,707,550.0
19	Хангамж, бараа материалын зардал	4,085,867.0	5,070,139.0
20	Нормативт зардал	287,232.9	253,244.6
21	Эд хогшил, урсгал засварын зардал	2,348,855.7	987,469.5
22	Томилолт, зочны зардал	437,533.9	443,336.2
23	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,564,572.8	9,246,806.7
24	Бараа үйлчилгээний бусад зардал	9,943,060.9	10,821,298.2
25	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,151,879.6	1,322,590.1
26	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	2,834,456.6
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	25,802,732.8	39,734,846.9
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	700.0
29	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	18,976,349.0	10,343,988.6
30	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(18,976,349.0)	(10,343,288.6)
31	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	6,826,383.7	29,391,558.3

2.3 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөг)

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	125,087,749.1	125,087,749.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	728,186.3	728,186.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	125,815,935.5	125,815,935.5
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(236,723.6)	(236,723.6)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(68,180.0)	(68,180.0)
6	Өмчид гарсан өөрчлөлт	87,721.4	87,721.4
7	Тайлант үеийн үр дүн	6,827,671.9	6,827,671.9
8	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	132,426,425.2	132,426,425.2
9	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	132,426,425.2	132,426,425.2
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(55,154.4)	(55,154.4)
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	132,371,270.8	132,371,270.8
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(9,721.3)	(9,721.3)
13	Өмчид гарсан өөрчлөлт	21,710.9	21,710.9
14	Тайлант үеийн үр дүн	29,391,558.3	29,391,558.3
15	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	161,774,818.6	161,774,818.6

2.4 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөг)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	89,033,731.7	96,093,257.3
2	ТАТВАРЫН ОРЛОГО	32,928,667.1	45,860,028.6
3	Хувь хүний орлогын албан татвар	22,467,541.3	26,222,480.7
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(959,323.0)	(1,306,128.9)
5	ААН-ын орлогын албан татвар	5,276,583.4	13,382,007.3
6	Хөрөнгийн албан татвар	3,493,646.7	3,031,660.3
7	Бусад татвар, төлбөр, хураамж	2,650,218.7	4,530,009.2
8	Бусад нийтлэг төлбөр, хураамж	536,538.8	719,789.9
9	Газрын төлбөр	1,498,352.6	2,108,207.3
10	Байгалийн нөөц ашигласны төлбөр	615,166.3	1,702,011.8
11	Бусад татвар	161.0	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	53,886,552.4	50,233,228.7
13	Нийтлэг татварын бус орлого	10,931,261.0	10,140,570.5
14	Хөрөнгийн орлого	294,140.5	76,139.2
15	Тусламжийн орлого	-	2,228,133.5
16	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	42,661,150.9	37,788,385.6
17	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,218,512.3	-
18	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	61,769,390.5	65,613,972.7
19	УРСГАЛ ЗАРДАЛ	61,769,390.5	65,613,972.7
20	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	59,654,766.1	64,508,251.8
21	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,230,839.0	26,166,669.5
22	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,139,970.4	3,599,580.3
23	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,198,035.2	17,846,563.5
24	Хангамж, бараа материалын зардал	3,139,487.2	2,759,393.1
25	Нормативт зардал	13,331.9	36,869.4
26	Эд хогшил, урсгал засварын зардал	2,293,107.5	1,150,018.2
27	Томилолт, зочны зардал	425,989.9	414,293.0
28	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,974,640.4	7,662,701.9
29	Бараа үйлчилгээний бусад зардал	6,239,364.6	4,872,163.0
30	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,114,624.4	1,105,720.9
31	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	27,264,341.2	30,479,284.6
32	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	46,514.4	52,663.8
33	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	22,859,990.8	15,918,094.7
34	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,859,990.8	15,918,094.7
35	Дотоод эх үүсвэрээр	22,859,990.8	15,918,094.7
36	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(22,813,476.4)	(15,865,430.9)
37	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	354,106.3	793,727.9
38	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(354,106.3)	(793,727.9)
39	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	4,096,758.6	13,820,125.8
40	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,954,358.8	13,051,117.4
41	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,051,117.4	26,871,243.2

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1 АУДИТЫН ТАЛААРХ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

3.1.1 Аудит хийсэн үндэслэл

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийв.

3.1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ

Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, УСНББОУС, СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Аймгийн Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгуудыг Аудитын олон улсын стандартын дагуу сорих аудитын горимыг төлөвлөж, хэрэгжүүлсэн.

Төрийн аудитын байгууллага нь Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргахын өмнө Төрийн аудитын тухай болон Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн захирагчид, төсөл, хөтөлбөр, сан, орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

3.1.3 Аудитын арга зүй

Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг үндсэн шалгуур болгон хяналтын сорил, шинжилгээний горим гүйцэтгэж, түүврээр ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, үнэлгээ өгөв.

3.1.4 Материаллаг байдлын түвшин

Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд төсвийн байгууллага, төрийн сан, төсөл, хөтөлбөр, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгтгэсэн тул материаллаг байдлын түвшнийг төлөвлөлтийн үе шатанд Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт орлогын 96,093.2 сая төгрөгийн 1.5 хувь буюу 1,441.4 сая төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ

Аймгийн Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх заалтын дагуу 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэн, 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын болон Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу дараах байдлаар бэлтгэсэн байна. Үүнд:

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд Засаг даргын аймаг, сумдын хоорондын тооцоогоор баталгаажуулсан өр төлбөр, авлага, ажил гүйлгээний давхардсан 220.6 сая төгрөгийг санхүүгийн байдлын тайланд, 146,018.3 сая төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд, 146,149.3 сая төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд тус тус цэвэрлэх бичилт хийсэн;

- Төсвийн байгууллага, төсөл сан, төрийн сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд гэсэн төрлөөр ангилан тайлагнасан байна.

Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд орон нутгийн төсөвт байгууллагын 46, төсөл сангийн 59, төрийн сангийн нэгжийн 21, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 13, хяналтад байгаа 11 нэгж, байгууллага болон орон нутгаас тогтмол зардлын болон төрийн үйлчилгээний зардлын санхүүжилт авсан байгууллагын 104 тайлан нийт 254 нэгжийн тайланг нэгтгэсэн байна.

3.2.1 Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж

Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр, нэгтгэсэн санхүүгийн тайлан болон тодруулга тайланг төгрөгөөр илэрхийлжээ.

3.2.2 Санхүүгийн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн

Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Санхүүгийн мэдээллийн технологийн төвийн “Fin-perform” программаар нэгтгэн гаргасан ба үндсэн цэсээс бүрдсэн байна. Үүнд:

Хүснэгт 1. “Fin-perform” программын үндсэн цэс, тайлбар

Үндсэн цэс	Тайлбар
1 Мэдээ, мэдээлэл	Системийн хэрэглэгч нарт зориулсан гарын авлага, аудитын дүгнэлт хэсгийг харах
2 Хариуцагч эрх	Нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг сум, байгууллага, нэгжийг хариуцагч нарын мэдээллийг харуулах
3 Тайлан хянах	Нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг сум, байгууллага, нэгжүүдийн санхүүгийн тайлангуудыг хянаж баталгаажуулах
4 Байгууллага	Байгууллагын ерөнхий мэдээллийг хөндөлөнгийн системүүдээс татаж харах
5 Байгууллагын жагсаалт	Нэгжүүдийн төсвийн ангилал, шатлалын ерөнхий мэдээллийг харах
6 Тайлан	Тайлан шивэх, илгээх, өөрийн илгээсэн тайланг буцаах үйлдэл хийх, дээд шатны байгууллагын “тайлан хянах эрх”-ээр өөрийн харьяа байгууллагуудын баталгаажсан тайлангуудын нэгтгэл харах, үндсэн болон хөтөлбөр тайланг хамтад нь харах
7 Устгал	Байгууллага, нэгжийн ангилал, шатлалын хооронд шилжүүлсэн төсвийн устгал бичилтийг харах
8 Статистик нэгтгэл	Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн статистик нэгтгэлийг харуулах

Эх сурвалж: Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн систем

“Fin-perform” программд нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хянах эрхээр нэвтэрч, тайлангийн тулгалтыг хийсэн.

3.3 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

3.3.1 Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн 179,201.4 сая төгрөг болж, өмнөх оноос 21.0 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 2. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч Тайлангийн үзүүлэлт	(сая төгрөг)			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Эргэлтийн хөрөнгийн дүн	42,662.6	55,855.0	13,192.4	31.2
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	105,229.6	123,346.4	18,116.7	707.8
Нийт хөрөнгийн дүн	147,892.2	179,201.4	31,309.1	110.8
Нийт өр төлбөр	15,461.5	17,426.6	1,965.0	9.7
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	132,430.7	161,774.8	29,344.1	90.3
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	147,892.2	179,201.4	31,309.1	100.0

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Нийт хөрөнгө өмнөх оноос 31,309.1 сая төгрөгөөр өссөн нь аймаг, сумдын орон нутгийн орлого, ОНХС-ийн мөнгөн хөрөнгө 13,820.1 сая төгрөгөөр нэмэгдэж, төрийн байгууллагууд 15,217.1 сая төгрөгийн биет бус хөрөнгийг улс орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар бүртгэж, ОНӨААТҮГ-ууд 1,166.2 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан нь голлон нөлөөлжээ.

3.3.2 Нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны нийт үр дүн 29,391.5 сая төгрөгийн (орлого нь зардлаасаа их) эерэг үзүүлэлттэй гарсан байна.

Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлангаар нийт үр дүн 22,565.2 сая төгрөгөөр өссөн.

Говь-Алтай аймгийн Засаг даргын тайланд нэгтгэгддэг 13 орон нутгийн өмчит аж ахуй нэгжүүд нийт дүнгээр 976.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

3.3.3 Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлангаар дахин үнэлгээний нөөц 22.6 сая төгрөгөөр, хуримтлагдсан үр дүн 29,371.0 сая төгрөгөөр, нийт 29,348.4 сая төгрөгөөр өссөн байна.

3.3.4 Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлангаар үйл ажиллагааны мөнгөн орлого 96,093.2 сая төгрөг, урсгал зардал 65,613.9 сая төгрөг, хөрөнгийн зардал 15,918.1 сая төгрөг, үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ 13,820.1 сая төгрөгийн эерэг үзүүлэлттэй илэрхийлэгдсэн байна.

4. АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 13,051.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 26,871.2 сая төгрөг болж, 13,820.2 сая төгрөгөөр буюу 205.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Мөнгөн хөрөнгө дансны ангилал		(сая төгрөг)			
Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
31	1 МӨНГӨН ХӨРӨНГӨ ДҮН	13,051.1	26,871.2	13,820.2	100.0
31100	1.1 Кассад байгаа бэлэн мөнгө	8.5	3.8	(4.7)	0.01
31110	1.1.1 Төгрөг	8.5	3.8	(4.7)	0.01
31200	1.2 Банкинд байгаа бэлэн мөнгө	13,042.6	26,867.4	13,824.9	99.9
31210	1.2.1 Төгрөг	13,042.6	26,867.4	13,824.9	99.9
31211	1.2.1.1 Төрийн сангийн харилцах	12,361.2	25,454.6	13,093.4	94.7

31213	1.2.1.3	Арилжааны банк дахь харилцах	673.9	1,412.8	739.0	5.3
31215	1.2.1.5	Нэмэлт санхүүжилтийн харилцах	7.5	-	(7.5)	-

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 13,820.2 сая төгрөгөөр өссөн ба мөнгөн хөрөнгийн 99.9 хувь нь банканд байршиж байгаа бол 0.01 хувь нь кассын дансанд байршиж байна.

Кассад байгаа бэлэн мөнгө 4.7 сая төгрөгөөр буурсан нь Ундарга-Алтай ААТҮГ-ын кассын үлдэгдэл буурсантай холбоотой.

Банканд байгаа бэлэн мөнгөний 94.7 хувь нь төрийн сангийн харилцах дансанд, 5.3 хувь нь арилжааны банкны дансанд байршиж байна.

- Төрийн сангийн харилцах дансанд байршиж байгаа мөнгөн хөрөнгө 13,093.4 сая төгрөгөөр өссөн нь аймгийн ОНХС-ийн 3,768.1 сая төгрөгөөр, аймаг, сумдын орон нутгийн ерөнхий орлого 7,641.5 сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна. Энэ нь жилийн эцэст Сангийн яамнаас урамшуулал, бичиг хэрэг, тавилга эд хогшил, бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, хөрөнгийн зардлын эрх хязгаарлагдсан холбоотой;
- Арилжааны банканд байршиж байгаа мөнгөн хөрөнгө 739.0 сая төгрөгөөр өссөн нь Алтай орон сууцны корпорац ААТҮГ-ын мөнгөн хөрөнгө 1,296.4 сая төгрөг буюу өмнөх оноос 786.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн;
- Нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд байршиж байгаа мөнгөн хөрөнгө 7.5 сая төгрөгөөр буурсан нь Баянтоорой тосгоны Захирагчийн албаны мөнгөн хөрөнгийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Төсөл, сангийн мөнгөн хөрөнгө

Сумдын байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа дансны эхний үлдэгдэл 375.7 сая төгрөг, тайлант онд 70.6 сая төгрөгийн барьцааг нэмж төвлөрүүлэн, 0.1 сая төгрөгийг нийгмийн хариуцлагын хүрээнд хандиваар шилжүүлэн авч, 24.0 сая төгрөгийн төлбөрийн акт төвлөрч, 126.8 сая төгрөгийн барьцааг чөлөөлж, 2.4 сая төгрөгийг урсгал зардал зарцуулан, 3.3 сая төгрөгийн торгуулийн мөнгө төлж, 2.0 сая төгрөгийг нөхөн сэргээлтэд зарцуулж, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 335.8 сая төгрөг байна.

Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 1,095.8 сая төгрөг, тайлант онд 298.5 сая төгрөгийн барьцааг байршуулан, 921.7 сая төгрөгийг /чанарын баталгаа, техник хяналтын зардал, зураг төсөв, зохиогчийн хяналтын зардал/ зарцуулан, мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 472.6 сая төгрөг байна.

Техникийн хяналтын дансны эхний үлдэгдэл 76.5 сая төгрөг бөгөөд тайлант онд 24.4 сая төгрөгийн орлого төвлөрч, 4.5 сая төгрөгийг Орон зай консалтинг ХХК-д хяналтын зардлыг шилжүүлж, 96.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

- Техник хяналтын 100050051370 тоот дансанд 5-аас дээш жилийн насжилттай хяналт хийгээгүй 10 ажлын 25.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

4.2 АВЛАГА

Авлага дансны эхний үлдэгдэл 12,967.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 12,521.2 сая төгрөг болж, 446.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Авлага дансны ангилал, байгууллагын төрлөөр

(сая төгрөг)

Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчидтай холбогдсон авлага	47.4	60.9	13.5	0.5
Татаас, санхүүжилтийн авлага	104.4	25.4	(79.0)	0.2
Зээлийн хүүгийн авлага	80.0	72.4	(7.6)	0.6

Дансны авлага /ТӨҮГ/	3,844.9	3,188.4	(656.5)	25.5
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	26.3	14.5	(11.8)	0.1
Бусад авлага	5,737.8	5,926.5	188.7	47.3
Байгууллагаас авах авлага	4,151.4	4,064.6	(86.8)	68.6
Хувь хүмүүсээс авах авлага	1,586.4	1,862.0	275.5	31.4
Зээлийн авлага	3,126.4	3,233.1	106.7	25.8
Хувь хүмүүст олгосон зээлийн авлага	2,979.2	3,140.9	161.7	97.1
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	147.2	92.2	(55.0)	2.9
Дүн	12,967.2	12,521.2	(446.0)	100.0

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Авлагын бууралтад Алтай орон сууцны корпорац ААТҮГ-ын дансны авлага (ТӨҮГ) 892.3 сая төгрөгөөр барагдсан нь голлон нөлөөлжээ.

Ажиллагчидтай холбогдсон авлага

Ажиллагчидтай холбогдсон авлагын эхний үлдэгдэл 47.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 60.9 сая төгрөг болж, 13.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Байгаль орчны газрын авлага 12.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Авлагын үлдэгдлийн 15.7 сая төгрөгийг Гэгээн нуур цэвэр ус ААТҮГ, 14.0 сая төгрөгийг Алтай хотын тохижилт үйлчилгээний газар, 12.7 сая төгрөгийг Байгаль орчны газар, 7.0 сая төгрөгийг Есөнбулаг сумын ИТХ, 3.1 сая төгрөгийг Есөнбулаг сумын ЗДТГ, 3.0 сая төгрөгийг Эрдэнэ сумын ЗДТГ, 1.8 сая төгрөгийг аймгийн ЗДТГ, 1.6 сая төгрөгийг Эрдэнэ эрчим хүч ААТҮГ, 1.6 сая төгрөгийг Гуулин тосгоны Захирагчийн алба, 0.4 сая төгрөгийг Дэлгэр сумын ЗДТГ-ын авлага эзэлж байна.

Гэгээн нуур цэвэр ус ОНӨААТҮГ, Эрдэнэ сумын эрчим хүч ОНӨААТҮГ-ууд нь татан буугдсан боловч авлага, балансын үзүүлэлтийг нэгтгэсэн хэвээр байна.

Есөнбулаг сумын ИТХ, ЗДТГ, Гуулин тосгоны захирагчийн алба, Алтай хотын тохижилт үйлчилгээний газрын авлагууд нь цалингийн нөхөн олговортой холбоотой бөгөөд төлөгдөөгүй байна.

Татаас санхүүжилтийн авлага

Татаас санхүүжилтийн авлагын дансны эхний үлдэгдэл 104.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 25.4 сая төгрөг болж, 79.0 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь Марал-Алтай, Жаргалан-Алтай, Энх-Алтай өрхийн эрүүл мэндийн төвүүдийн Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн авлагыг барагдуулсан байна.

Зээлийн хүүгийн авлага

Зээлийн хүүгийн авлагын дансны эхний үлдэгдэл 80.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 72.4 сая төгрөг болж, 7.6 сая төгрөгөөр буурсан нь ХХС-аас олгосон зээлийн хүүгийн авлагыг барагдуулсантай холбоотой.

Дансны авлага (ТӨҮГ)

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эхний үлдэгдэл 3,844.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 3,188.4 сая төгрөг болж, 656.5 сая төгрөгөөр буурсан байна. Алтай орон сууцны корпорац ААТҮГ-ын авлага 892.3 сая төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн.

Татвар НДШ-ын авлага

Татвар НДШ-ийн авлагын эхний үлдэгдэл 26.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 14.5 сая төгрөг болж, 11.8 сая төгрөгөөр буурсан нь Солонго дулааны станц ААТҮГ, Алтай орон сууцны корпорац ААТҮГ-ын нэмэгдсэн өртгийн албан татварын авлагыг барагдуулсан байна.

Бусад авлага

Бусад авлагын эхний үлдэгдэл 5,737.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,926.5 сая төгрөг болж, 188.7 сая төгрөгөөр өссөн байна.

Бусад авлага 188.7 сая төгрөгөөр өссөн нь Алтай орон сууцны корпорац ААТҮГ-ын авлага 522.9 сая төгрөг, аймгийн ЗДТГ-ын авлага 260.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Авлагын үлдэгдлийн 2,731.3 сая төгрөг буюу 46.0 хувийг Алтай орон сууцны корпорац ААТҮГ-ын аймгийн ЗДТГ-аас авах орон сууцны нэмэгдүүлсэн хүүгийн авлага эзэлж байна. Тус авлагыг аймгийн ЗДТГ-тай тооцоо нийлж баталгаажуулаагүй бөгөөд тайланд тусгасан байна.

Авлагын үлдэгдлийн 1,400.1 сая төгрөг буюу 23.6 хувийг тусгай сангуудаас (ОНХС, ХХС, ЖДҮДС, МХС, ТЭДС) олгосон зээл болон урьдчилгаа төлбөрийн авлага, 950.4 сая төгрөг буюу 15.5 хувийг сумдын ИТХ, ЗДТГ-ын авлага, 589.5 сая төгрөг буюу 9.0 хувийг ААТҮГ-ын авлага, 255.2 сая төгрөг буюу 5.9 хувийг бусад байгууллагуудын (Төрийн архивын хэлтэс, Ойн анги, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн) авлага эзэлж байна.

Зээлийн авлага

Сумдын ХХС-гийн авлага дансны 2,638.6 сая төгрөгийн үлдэгдлийн 29.9 хувь буюу 789.9 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн зээлийн авлага бөгөөд 13.0 хувь буюу 101.4 сая төгрөгийн зээлийг Шүүхэд хандаагүй, арга хэмжээ аваагүй байна.

Алтай, Дэлгэр, Есөнбулаг, Цогт, Хөхморьт, Чандмана, Эрдэнэ сумдын ХХС-гийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 12 иргэн, хоршоодын зээлийг төлүүлэх шүүхийн шийдвэр гарч, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай гэрээ байгуулсан боловч 2019-2021 онд тухайн үеийн сумын Засаг дарга нар эргүүлэн татан авч зээлийг төлүүлээгүй, зээлийн үлдэгдэл 87.9 сая төгрөг байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон ХХС-гийн төлбөрийн актын үлдэгдэл хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 687.2 сая төгрөгийг төлүүлээгүй байна. Энэ нь эх үүсвэр дутагдах, зээлийн эргэлтийг удаашруулах эрсдэлийг үүсгэж байна.

МХС, ЖДҮДС, ТЭДС-гуудаас олгосон зээлийн эргэн төлөлт хийгдээгүй, хугацаа хэтэрсэн нийт 472.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. (дэлгэрэнгүйг хавсралт №1-ээс харна уу)

ТШЗ-ын санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

- Он дамжсан авлага 345.2 сая төгрөгийг барагдуулаагүй. (Хөхморьт сумын ОНХС-201.3 сая төгрөг, Халиун сумын ОНХС-73.6 сая төгрөг, Төгрөг сумын ОНХС-18.1 сая төгрөг, Дэлгэр сумын ОНХС-15.2 сая төгрөг, Дарив сумын ОНХС-10.2 сая төгрөг, Тонхил сумын ОНХС-10.0 сая төгрөг, Чандмань сумын ОНХС- 7.7 сая төгрөг, Цогт сумын ОНХС-7.1 сая төгрөг, Шарга сумын ОНХС-1.1 сая төгрөг, МХС - 0.9 сая төгрөг).
- Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн акт үйлдэж, баталгаажуулаагүй 275.9 сая төгрөг байна. (аймгийн ЗДТГ-264.5 сая төгрөг, Солонго дулааны станц ААТҮГ-11.4 сая төгрөг);
- Тайлант онд 25.5 сая төгрөгийн авлага үүсээсэн. (Нийтлэг үйлчилгээ ААТҮГ-25.5 сая төгрөг, Ундарга-алтай ААТҮГ, Байгаль орчны газар);

Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

- Тайлант онд аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр бэлтгэсэн 338.6 сая төгрөгийн өвс тэжээлийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, харилцагчаар бүртгээгүй байна.

4.3 УРЬДЧИЛГАА

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 168.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 165.4 сая төгрөг болж, 3.3 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Үзүүлэлт	Хүснэгт 5. Урьдчилгаа данс байгууллагын төрлөөр			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	(сая төгрөг) Дүнд эзлэх хувь
Солонго дулааны станц ААТҮГ	149.0	149.0	-	88.3
Эрдэнэ-Эрчим хүч ААТҮГ	16.4	16.4	-	9.7
Марал-Алтай ӨЭМТ	1.8	0.04	(1.8)	1.1
Эрдэнэ сумын ЗДТГ	1.5	-	(1.5)	0.9
Дүн	168.7	165.4	(3.3)	100.0

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд Солонго дулааны станц ААТҮГ-ын хүлээж аваагүй дулааны шугамын ажлын 149.0 сая төгрөг, Эрдэнэ-Эрчим хүч ААТҮГ-ын дуусаагүй шугамын ажлын 16.4 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд Марал-Алтай өрхийн эрүүл мэндийн төв 1.8 сая, Эрдэнэ сумын ЗДТГ-1.5 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг барагдуулсан байна.

4.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 5,904.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6,406.1 сая төгрөг болж, 501.7 сая төгрөгөөр өссөн байна.

Үзүүлэлт	Хүснэгт 6. Бараа материал данс байгууллагын төрлөөр			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	(сая төгрөг) Дүнд эзлэх хувь
Түүхий эд материал	362.5	386.2	23.7	6.0
Тусгай зориулалттай материал	319.7	350.4	30.7	90.7
Эм боох материал	42.8	35.8	(7.1)	9.3
Бэлэн бүтээгдэхүүн	144.0	175.6	31.6	2.7
Хангамжийн материал	3,136.9	3,388.6	251.7	52.9
Бичиг хэргийн материал	43.4	40.5	(2.9)	1.2
Аж ахуйн материал	2,421.7	2,719.3	297.6	80.2
Сэлбэг хэрэгсэл	64.4	65.3	0.8	1.9
Түлш, шатах тослох материал	50.6	68.1	17.5	2.0
Барилгын засварын материал	41.6	40.1	(1.5)	1.2
Хүнсний материал	1.3	0.5	(0.8)	0.0
Бусад хангамжийн материал	513.9	454.8	(59.1)	13.4
Мал амьтад	2,261.0	2,455.7	194.7	38.3
Дүн	5,904.4	6,406.1	501.7	100.0

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Тайлант онд хангамжийн материал 251.7 сая төгрөгөөр, мал амьтад 194.7 сая төгрөгөөр, бэлэн бүтээгдэхүүн 31.6 сая төгрөгөөр, түүхий эд материал 23.7 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 4,574.3 сая төгрөгийн бараа материалыг бэлтгэж, 125.8 сая сая төгрөгийн бараа материалыг бусад эх үүсвэрээс хандиваар авч, 3,873.8 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан, 135.5 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлэн, 188.8 сая төгрөгийн бараа материалыг акталж устган, 6,406.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Сумдын ХХС-гийн бараа материал дансанд 145.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй /Халиун сум 36.3 сая төгрөг, Баян-Уул сум 34.6 сая төгрөг, Бигэр сум 19.2 сая төгрөг, Жаргалан сум 15.2 сая төгрөг, Бугат сум 11.7 сая төгрөг, Цээл сум 9.4 сая төгрөг, Чандмань сум 7.4 сая төгрөг, Алтай сум 5.3 сая төгрөг, Төгрөг сум 4.0 сая төгрөг, Дарив сум 2.1 сая төгрөг/ оёдлын тоног төхөөрөмжүүд байгаа бөгөөд 7-8 жил ашиглалтгүй хадгалагдаж байна.

ТШЗ-ын санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

- Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрэгүйгээр 8.8 сая төгрөгийн бараа материал акталж устгаасан. (Шарга сумын ЗДТГ 6.4 сая төгрөг, Тонхил сумын ИТХ 2.4 сая төгрөг);
- Анхан шатны баримтгүй 3.5 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан. (Алтай сумын ЗДТГ);
- Бараа материалын тооллогыг хийгээгүй, тооцоо бодоогүй. (Эрдэнэ сумын ЗДТГ, Баянтоорой тосгоны Захирагчийн алба, Инновац судалгаа бизнес хөгжлийн төв УТҮГ).

Нөөцийн бараа

Нөөцийн бараа дансны эхний үлдэгдэл 558.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 625.7 сая төгрөг болж, 67.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7.Нөөцийн бараа данс байгууллагын төрлөөр (сая төгрөг/)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Барааны нөөц	55.9	43.7	(12.2)	7.0
Үрийн нөөц	109.7	106.0	(3.7)	16.9
Тэжээлийн нөөц	243.6	272.8	29.2	43.6
Бусад нөөц	149.3	203.2	53.9	32.5
Дүн	558.5	625.7	67.2	100.0

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Нөөцийн барааны дансны үлдэгдлийн 106.0 сая төгрөг буюу 21.7 хувийг Халиун сум, 88.5 сая төгрөг буюу 14.1 хувийг Дэлгэр сум, 431.2 сая төгрөг буюу 64.2 хувийг бусад сумд эзэлж байна.

Нөөцийн барааны эхний үлдэгдэл 558.5 сая төгрөг байхад тайлант онд сумдын ОНХС-ийн эх үүсвэрээр 381.9 сая төгрөгийн өвс тэжээлийн нөөц дахин бэлтгэсэн байна. Жил бүр өвс тэжээлийн нөөц бүрдүүлж байгаа эргэлтийн хөрөнгө нэмэгдэн, авлага нэмэгдсэн байна. Иймд нөөцөд байгаа өвс тэжээлийг худалдан борлуулж, хөрөнгийг төвлөрүүлэн эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр болгон ашиглах нь зүйтэй байна.

4.5 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Бусад эргэлтийн хөрөнгийн эхний үлдэгдэл 10,012.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 9,265.2 сая төгрөг болж, 747.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8.Бусад эргэлтийн хөрөнгө данс байгууллагын төрлөөр (сая төгрөг/)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/ + Бусад	9,128.2	6,955.8	(2,172.4)	75.1
БЗЭБуй эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	884.3	2,309.4	1,425.1	24.9
Дүн	10,012.5	9,265.2	(747.3)	100.0

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Орон нутгийн хөгжлийн сангийн бусад эргэлтийн хөрөнгө 2,172.4 сая төгрөгөөр буурсан нь сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж дуусаагүй төсөл арга хэмжээнүүдийг бараа материалын данснаас хасаж, үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн хөрөнгө 1,425.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн дуусаагүй ажлуудыг бүртгэсэн байна.

Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

- Аймгийн хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжсэн 2-оос дээш жил болж байгаа 1,214.9 төгрөгийн өртөг бүхий 32 төсөл, арга хэмжээг борлуулах зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгөнд бүртгэсэн;
- Сум дундын Хөдөө аж ахуйн бааз байгуулах зорилгоор худалдан авсан 682.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланд борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн хөрөнгөөр 2021 оноос хойш бүртгэсэн;

4.6 ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл цэвэр дүнгээр 105,229.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 123,346.4 сая төгрөг болж, 18,116.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	(сая төгрөг)	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Биет хөрөнгө	82,845.3	100,472.7	17,627.4	81.5
Биет бус хөрөнгө	22,384.3	22,873.7	489.3	18.5
Дүн	105,229.6	123,346.4	18,116.7	100.0

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Тайшир, Баян-Уул сумд Засгийн газрын хэрэг эрхлэх газраас эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар 4,841.6 сая төгрөгийн балансын үнэтэй Иргэдэд үйлчлэх мэдээллийн төв ашиглалтад орсныг бүртгэлд тусгасан байна.

Мөн улс, орон нутгийн төсөв, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 3,467.8 сая төгрөгийн 25 төсөл арга хэмжээг бүртгэлд тусгасан байна.

ТШЗ-ын санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

- Үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй, тооцоо бодоогүй 452.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн. (Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ 452.6 сая төгрөг, Ундарга-Алтай ААТҮГ);
- Хөрөнгийг орлого аваагүй, данс бүртгэлд тусгаагүй 340.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн. (Ундарга-Алтай ААТҮГ 212.0 сая төгрөг, аймгийн ОНХС 107.6 сая төгрөг, Инноваци бзнес хөгжлийн төв 21.0 сая төгрөг, Төрийн архивын хэлтэс);
- Үндсэн хөрөнгийг шийдвэрлэжээгээр 18.3 сая төгрөгийн хөрөнгийг байгууллагад шилжүүлсэн байна. (Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ);
- Хөрөнгийг актлах 7.8 сая төгрөгийн шийдвэр гарсан байхад актлаагүй. (Ундарга-Алтай ААТҮГ);
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэлд 1.1 сая төгрөгийн номыг бөөн дүнгээр бүртгэсэн. (Бугат ЗДТГ).

4.7 ӨР ТӨЛБӨР

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 15,461.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 17,426.5 сая төгрөг болж, 1,965.1 сая төгрөгөөр өссөн байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	(сая төгрөг)	
			Өссөн (+), Буурсан (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	6,057.1	7,666.0	(1,608.9)	44.0
Ажиллагсадтай холбоотой өглөг	294.5	132.9	161.5	1.7
Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,131.1	1,220.9	(89.8)	15.9
Бусад өглөг	3,279.8	5,653.2	(2,373.4)	73.7
Урьдчилж орсон орлого	1,351.8	659.0	692.7	8.6
Урт хугацаат өр төлбөр дүн	9,404.4	9,760.6	(356.2)	56.0
Урт хугацаат зээл	9,404.4	9,760.6	(356.2)	56.0
Дүн	15,461.5	17,426.5	(1,965.1)	100.0

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Нийт өр төлбөрийн 56.0 хувь буюу 9,760.6 сая төгрөг нь урт хугацаат өр төлбөр, 43.9 хувь буюу 7,666.0 сая төгрөг богино хугацаат өр төлбөр эзэлж байна.

Богино хугацаат өр төлбөр 1,608.9 сая төгрөгөөр өссөн нь төсвийн байгууллагуудын тогтмол зардлын өр төлбөр өмнөх оноос 2.5 дахин буюу 2,610.7 сая төгрөгөөр өссөн байна. Гэвч жилийн эцэст татаас санхүүжилтийг тодотгож, төрийн сангаас авлага, өглөг үүсгээгүй санхүүжилтийг өр төлбөртэй уялдуулж олгоогүй байна.

Богино хугацаат өр төлбөрийн 4,311.5 сая төгрөг буюу 56.0 хувийг тогтмол зардал, 2,833.4 сая төгрөг буюу 37.0 хувийг бусад зардал, 510.7 сая төгрөг буюу 7.0 хувийг цалин, НДШ, ХХОАТ-ын зардал эзэлж байна.

Урт хугацаат өр төлбөр 9,760.5 сая төгрөг болж, 356.2 сая төгрөгөөр өссөн нь Ундарга-Алтай ААТҮГ-ын урт хугацаат зээлийн хүүгийн төлбөр 209.9 сая төгрөгийг, Алтай орон сууцны корпорац ААТҮГ дамжуулан зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр 146.2 сая төгрөгийг тус тус нэмж бүртгэсэн байна.

Монгол Улсын Хөгжлийн банкнаас Алтай орон сууцны корпораци ААТҮГ-т 2019 онд олгосон урт хугацаат 7,830.5 сая төгрөгийн зээлээс өмнөх онуудын 4,399.4 сая төгрөг, 2025 оны 1,209.1 сая төгрөг, нийт 5,608.5 сая төгрөгийн үндсэн болон хүүгийн төлбөрийг төлөөгүй, хугацаа хэтэрсэн. Зээлийн гэрээний дагуу тооцож үзэхэд 2019 оноос хойш урт хугацаат зээлийн хүүгийн төлбөрт 2,398.0 сая төгрөг, алданги 862.8 сая төгрөг, нийт 3,260.8 сая төгрөгийг тооцоо нийлээгүйгээс бүртгэлд тусгаагүй байна.

Сангийн яам, Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээгээр Ундарга-Алтай ААТҮГ-т нийтийн аж ахуйн суурь үйлчилгээг сайжруулах төслийн зээлээс хугацаа хэтэрсэн, эргэн төлөлт хийгдээгүй 1,094.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

ТШЗ-ын санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

- Тайлант онд 126.5 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөртэй гарч, төсвийг зохистой удирдаагүй. (Марал-Алтай өрхийн эрүүл мэндийн төв-68.2 сая төгрөг, Нийтлэг үйлчилгээ ОНӨҮГ-23.8 сая төгрөг, Дарив сумын ИТХ-23.6 сая төгрөг, Тонхил сумын ИТХ-6.2 сая төгрөг, Хөхморьт сумын ЗДТГ-4.7 сая төгрөг);

Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт

- Тайлант онд харьяа байгууллагууд тогтмол зардлын 4,311.5 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаа нь өмнөх оноос 2.5 дахин өссөн
- Мал хамгаалах сангийн эргэлтийн хөрөнгө 265.2 сая төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, 2010 оноос хойш богино хугацаат өр төлбөрөөр бүртгэсэн

4.8 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 132,430.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 161,430.8 сая төгрөг болж, 29,344.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 11. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	(сая төгрөг)	
			Өсөлт (+), бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	17,741.5	17,738.8	2.6	11.0
Өмч /төрийн/ ТӨҮГ	14,915.8	14,915.8	-	9.2
Хуримтлагдсан үр дүн	92,872.0	122,241.3	(29,369.4)	75.6
Өмнөх үеийн үр дүн	86,045.6	92,849.8	(6,804.2)	57.4
Тайлант үеийн үр дүн	6,826.4	29,391.6	(22,565.2)	18.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,901.5	6,878.9	22.6	42.5
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	132,430.8	161,774.8	(29,344.1)	100.0

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Дахин үнэлгээний нөөц 622.6 сая төгрөгөөр буурч, хуримтлагдсан үр дүн 29,386.6 сая төгрөгөөр өссөн нь шинээр хэрэгжсэн төсөл хөтөлбөр, улс, орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр бэлтгэсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

4.9 ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ БОЛОН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧДЫН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитад 20 Засаг дарга, захирагч, 120 төсвийн шууд захирагч, орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөл, хөтөлбөрийн нэгж санхүүгийн тайлангийн аудитад хамрагдахаас 51 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 92 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж, тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй татан буугдсан 2 ААТҮГ-ын санхүүгийн тайланг аудитад хамруулаагүй байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 9,596.7 сая төгрөгийн 77 зөрчил илэрснээс 25.3 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 3,231.6 сая төгрөгийн зөрчилд 49 албан албан шаардлага, 6,145.9 сая төгрөгийн 20 зөвлөмж, 193.8 сая төгрөгийн зөрчилд 7 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 38,463.9 сая төгрөгийн 279 алдаа илэрснийг аудитын явцад удирдлага, нягтлан бодогчийн зөвшөөрснөөр залруулга хийсэн.

Дүгнэлт гаргасан төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудит

Аудитын дүгнэлт гаргасан 31 байгууллагаас өөрчлөлтгүй 12, хязгаарлалттай 19 байгууллага байна.

Төсвийн 20 Засаг дарга, захирагчийн санхүүгийн тайланд аудит хийж, "Хязгаарлалттай" дүгнэлт авсан.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 19,187.2 сая төгрөгийн 89 алдаа илэрснээс бүрэн залруулсан.

Аудитаар нийт 4,639.6 сая төгрөгийн 181 зөрчил илэрснээс 121.7 сая төгрөгийн зөрчилд 18 төлбөрийн акт, 881.4 сая төгрөгийн зөрчилд 41 албан шаардлага, 277.2 сая төгрөгийн зөрчилд 11 албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцох албан шаардлага, 3,359.3 сая төгрөгийн 111 зөвлөмж хүргүүлсэн. (дэлгэрэнгүйг хавсралт 2-оос харна уу)

Түүвэрт хамруулсан байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудит

Түүвэрт 61 тусгай сан, 27 төсвийн байгууллага, 4 аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, нийт 92 байгууллага, тусгай сан хамрагдсан байна.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 15,846.6 сая төгрөгийн 162 алдаа илэрснийг залруулсан байна.

Аудитаар нийт 4,211.1 сая төгрөгийн 119 зөрчил илэрснээс 230.6 сая төгрөгийн зөрчилд 26 төлбөрийн акт, 2,824.0 сая төгрөгийн зөрчилд 42 албан шаардлага, 189.1 сая төгрөгийн 7 албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцох албан шаардлага, 967.4 сая төгрөгийн зөрчилд 48 зөвлөмж хүргүүлжээ. (дэлгэрэнгүйг хавсралт 3-аас харна уу)

Орон нутгийн өмчит аж ахуй нэгжийн санхүүгийн тайлангийн аудит

Орон нутгийн өмчийн 13 хуулийн этгээдээс 8 байгууллагад дүгнэлт гарган, 3 байгууллагыг түүвэрт хамруулан, 2 байгууллага аудитад хамрагдаагүй байна.

Аудитын дүгнэлт гаргасан 8 байгууллагаас өөрчлөлтгүй 2 (Суурин дулаан ААТҮГ, Нийтлэг үйлчилгээ УТҮГ), хязгаарлалттай 6 (Алтайн тохижилт үйлчилгээний газар ААТҮГ, Алтай орон сууцны корпорац ААТҮГ, Солонго дулааны станц ААТҮГ, Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ, Ундарга-Алтай ААТҮГ, аймгийн Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв УТҮГ) дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 2,966.0 сая төгрөгийн 22 алдаа илэрснийг залруулсан байна.

Аудитаар нийт 3,050.3 сая төгрөгийн 41 зөрчил илэрснээс 44.0 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт, 1,224.2 сая төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага, зөрчил гаргасан 4 албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 1,782.1 сая төгрөгийн 20 зөвлөмж хүргүүллээ. (дэлгэрэнгүйг хавсралт 4-өөс харна уу)

4.10 НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ, ЗАЛРУУЛГА

Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд 456.3 сая төгрөгийн дараах залруулгыг хийлээ. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн нэгтгэсэн тайланд Алтай хотын тохижилт үйлчилгээний газрын дуудлага худалдаагаар худалдсан 5 тээврийн хэрэгслийг 182.4 сая төгрөгөөр худалдан борлуулснаар тайлагнасан,
- Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 145.6 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрийг богино хугацаат өр төлбөрөөр тайлагнасан,
- Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 53.2 сая төгрөгийн авлагын устгах бичилтийг хийгээгүй,
- Алтай орон сууцны корпораци ААТҮГ-ын тайлант үеийн үр дүн 15.6 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн,
- Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 6,323.1 сая төгрөгийн 353 мэдээллээс бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн 59.4 сая төгрөгийн 8 мэдээллийг мэдээлээгүй байсныг нөхөн мэдээлүүлсэн.

Говь-Алтай аймгийн Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2,526.9 сая төгрөгийн 7 зөрчил илэрснээс, 25.3 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 1,214.9 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 1,286.7 сая төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлсэн.

4.10.1 Төлбөрийн акт

1. Техник хяналтын дансанд 5-аас дээш жилийн насжилттай хяналт хийгээгүй 10 ажлын 25.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх", Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

4.10.2 Албан шаардлага

1. Аймгийн хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжсэн 2-оос дээш жил болж байгаа 1,214.9 сая төгрөгийн өртөг бүхий 32 төсөл, арга хэмжээг борлуулах зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгөнд бүртгэсэн, хэрэгжиж дуусаагүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" Говь-Алтай аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

- Харьяа байгууллагуудын аудитаар 69.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,565.0 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 17 албан шаардлага, 6 албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцох албан шаардлага, 1,730.5 сая төгрөгийн 22 заалт зөвлөмж өгсөн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах албан шаардлага өгсөн.

4.11 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Говь-Алтай аймгийн Засаг даргын 2021-2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар 18,599.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 2.9 сая төгрөгийн төлбөрийн акт, 1 албан шаардлага хүргүүлж, 14,025.3 сая төгрөгийн 12 зөвлөмж өгснөөс хэрэгжилтийг хянаж, үнэлэхэд 52.3 хувьтай хангалтгүй байна.

Хүснэгт 12. Өмнөх санхүүгийн тайлангаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт (сая төгрөг)

Үзүүлэлт	Өмнөх оны шийдвэр		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	7	4,571.7	1	751.6	6	3,820.1	16.4
Төлбөрийн акт	1	2.9	-	-	1	2.9	-
Зөвлөмж	12	14,025.3	3	12,371.2	9	1,654.2	88.2
Дүн	20	18,599.9	4	13,122.8	16	5,477.1	52.3

Гүйцэтгэл, нийцлийн аудитын шийдвэрийн үлдэгдэл:

Төрийн аудитын байгууллагын 2022-2025 онд өөрийн санаачилга болон нэгдсэн бодлогоор хийсэн аудитаар 18.0 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 329.5 сая төгрөгийн 14 албан шаардлага хүргүүлж, 2,017.5 сая төгрөгийн 34 зөвлөмж өгснөөс хэрэгжилтийг хянаж, үнэлэхэд 6.0 хувьтай хангалтгүй байна.

4.12 ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь 2025 онд 6 орон тоотой ажиллахаас 4 орон тоотой ажилласан.

Тус газар нь Засаг даргын баталсан "Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-д тусгасны дагуу тухайн жилд аймгийн төвийн болон сумдын нийт 40 байгууллага, тусгай зориулалтын сангийн 2023-2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэлд хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр 29 төсөвт байгууллага, 8 тусгай зориулалтын сангийн 2023-2024 оны үйл ажиллагаанд хяналт хийсэн байна.

Хяналт шалгалтаар нийт 597.4 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 52.6 сая төгрөгийн 16 төлбөрийн акт тогтоож, 544.8 сая төгрөгийн 14 албан шаардлага хүргүүлж, төлбөрийн актын 46.1 хувь буюу 24.9 сая төгрөгийг төлүүлсэн байна.

Удирдах дээд байгууллагын шийдвэрээр аймгийн "Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар"-ын 2023-2024 оны аймгийн Засаг даргаас шилжүүлсэн болон

иргээдээс тус албанд хандан гаргасан өргөдөл, хүсэлт, гомдлын дагуу төлөвлөгөөт бусаар 3 хяналт хийсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг Засаг даргын харьяаны 87 байгууллагад хяналт хийж, улирал бүр Сангийн яамны дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт, үнэлгээний газарт хүргүүлсэн байна. Хуулийн хэрэгжилтийг хянахад 4 дүгээр улирлын байдлаар 97.5 хувьтай гэж дүгнэжээ.

4.13 Нягтлан бодох бүртгэлийн стандарт, тайлагналтай холбоотой

Засаг даргын 2025 оны аудитаар дараах 4 байгууллагатай холбоотой нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтлөөгүй, санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлээгүй, албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн Ундарга-Алтай ААТҮГ, Инноваци судалгаа, бизнес хөгжлийн төв УТҮГ-ын 4 албан тушаалтнуудад хуулийн дагуу сахилгын хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлсэн.

5.АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

5.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангаарх нийт хөрөнгийн дүн 17.0 хувиар өссөн үзүүлэлттэй;
2. Харьяа байгууллагууд тогтмол зардалд 4,311.5 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй;
3. Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрээр он дамжин хэрэгжиж дуусаагүй 1,214.9 сая төгрөгийн 32 төсөл, арга хэмжээг борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн хөрөнгөнд бүртгэн 2-3 жил болсон;
4. Алтай орон сууц корпораци ААТҮГ нь 5,608.5 сая төгрөгийн, Ундарга-Алтай ААТҮГ 1,094.0 сая төгрөгийн, нийт 6,702.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн урт хугацаат зээлийн үлдэгдэлтэй;
5. ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 338.6 сая төгрөгийн нөөцийн бараа, өвс тэжээлийн авлагыг харилцагч тус бүрээр бүртгээгүй;
6. МХС, ЖДҮДС, ТЭДС, ХХС-гаас олгосон зээлийн эргэн төлөлт хийгдээгүй, хугацаа хэтэрсэн нийт 1,202.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй;
7. Өмнөх онуудын санхүүгийн тайлангийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт 52.3 хувьтай, хангалтгүй байна.

5.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД:

1. Аймгийн Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайланд үүссэн тогтмол зардлын өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах.
2. ОНХС-ийн санхүүгийн тайланд бүртгэсэн 338.6 сая төгрөгийн өвс, тэжээлийн авлагыг харилцагч тус бүрээр тооцоо нийлж, авлагыг нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу бүртгэх.
3. МХС-ийн санхүүгийн тайланд 2010 оноос хойш бүртгэсэн 265.2 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөрийн тооцоог нийлж баталгаажуулж, барагдуулах.
4. ТЭДС-ийн санхүүгийн тайлангийн 5 жил борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн хөрөнгө ангилалд бүртгэсэн 682.9 сая төгрөгийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу бүртгэх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2027 оны 04 дүгээр сарын 15-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ХАВСРАЛТ.

Хавсралт 1. Тусгай сангуудаас олгосон зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл

Төрөл	Өмнөх онуудад олгосон зээл	Олгосон зээл 2025 онд	Хугацаа хэтэрсэн зээл			
			Үндсэн зээл	Хүү	Алданги	дүн
ТЭДС	90.7	-	15.8	0.5	1.2	17.5
МХС	318.0	48.0	40.2	-	-	40.2
ЖДҮДС	1,275.0	265.0	350.4	-	13.0	363.4
Дүн	1,683.7	313.0	406.4	0.5	14.2	421.1

Хавсралт 2. Дүгнэлт гаргасан байгууллагуудын зөрчлийн нэгтгэл

ДД	Байгууллагын нэр	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Илрүүлсэн зөрчил		Аудитаар залруулсан		Төлбөрийн акт		Албан шаардлага		Сахилгын шийтгэл оногдуулах		Зөвлөмж		Монгол Улсын Ерөнхий аудитор санал		Хууль хяналтын байгууллага			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
				сөрөг	сөрөг																
1	Алтай сум	1	1	9	1,085.5	2	1,066.3	-	-	2	8.7	1	-	4	10.5	-	-	-	-		
2	Баян-Уул сум	1	1	11	118.1	3	4.8	-	-	3	38.8	-	-	5	74.5	-	-	-	-		
3	Билэр сум	1	1	9	176.4	2	45.1	1	1.4	3	71.5	-	-	3	58.4	-	-	-	-		
4	Бугат сум	1	1	12	650.5	5	605.3	-	-	1	-	-	-	6	45.2	-	-	-	-		
5	Дарив сум	1	1	9	164.6	2	89.5	-	-	1	-	1	-	5	75.1	-	-	-	-		
6	Дэлгэр сум	2	2	10	102.5	1	21.8	2	3.3	1	-	1	19.9	5	57.5	-	-	-	-		
7	Жаргалан сум	2	2	9	239.0	3	169.2	1	0.9	1	-	-	-	4	68.9	-	-	-	-		
8	Тайшир сум	2	2	6	75.1	1	10	-	-	2	36.4	1	-	2	28.7	-	-	-	-		
9	Тонхил сум	1	1	15	1,474.7	7	1,238.7	2	40.4	1	-	-	-	5	195.6	-	-	-	-		
10	Төгрөг сум	2	2	17	1,173.5	8	1,091.6	1	0.5	1	-	-	-	7	81.4	-	-	-	-		
11	Халиун сум	2	2	14	2,287.9	4	2,067.9	-	-	2	94.0	1	-	7	126	-	-	-	-		
12	Хөхморьт сум	2	2	13	397.5	4	273.9	-	-	3	31.2	1	4.8	5	87.6	-	-	-	-		
13	Цогт сум	1	1	14	6,043.9	5	5,846.4	1	3.2	1	-	1	-	6	194.3	-	-	-	-		
14	Цээл сум	1	1	8	54.1	3	26.3	1	1.3	3	4.7	-	-	1	21.8	-	-	-	-		
15	Чандмань сум	2	2	7	98.1	-	-	-	-	1	-	-	-	6	98.1	-	-	-	-		
16	Шарга сум	2	2	22	1,054.2	10	983.0	2	1.2	2	-	-	-	8	70.0	-	-	-	-		
17	Эрдэнэ сум	2	2	12	533.3	3	438.6	2	3.5	3	25.0	-	-	4	66.2	-	-	-	-		
18	Гуудин тосгон	1	1	3	15.9	-	-	-	-	2	-	-	-	1	15.9	-	-	-	-		
19	Баянтоорой тосгон	1	1	6	86.5	2	60.4	-	-	1	-	-	-	3	26.1	-	-	-	-		
20	Есөнбулаг сум	3	3	33	4,161.4	14.0	3,341.4	5	66.0	2	4.7	3	252.5	9	496.8	-	-	-	-		
21	Аймаг дүн	2	2	31	3,834.1	10	1807.0	-	-	5	566.4	1	-	15	1,460.7	-	-	-	-		



НИЙТ ДҮН 10 33 0 270 23,827.0 89 19,187.2 18 121.7 41 881.4 11 277.20 111 3,359.3 0 0 0 0

Хавсралт 3. Түүвэрт хамрагдсан байгууллагуудын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

ДД	Байгууллагын нэр	түүвэрт хамрагдсан	Илрүүлсэн зөрчил		Аудитаар залруулсан		Төлбөрийн акт		Албан шаардлага		Сахилгын шийтгэл оноглуулах албан шаардлага		Зөвлөмж	
			тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн
1	Алтай сум	4	10	894.7	7	860.0	1	2.9	1	18.2	1	8.6	1	13.6
2	Баян-Уул сум	4	10	362.2	7	263.2	1	22.5			3	26.5	3	76.6
3	Бигэр сум	4	6	110.6	4	54.9	1	10.4			1	-	1	45.4
4	Бугат сум	4	10	70.1	6	49.3	1	2.9	2	88.1	2	-	2	17.9
5	Дарив сум	4	25	1,176.8	16	1,009.9	1	15.8	3	88.1	5	8.6	5	63.0
6	Дэлгэр сум	4	12	453.3	6	376.2	3	12.2	4	22.2	1	-	1	42.7
7	Жаргалан сум	4	8	314.5	7	298.5	1	16.0	0	-	0	-	0	-
8	Тайшир сум	4	9	204.9	8	204.0	1	0.9	0	-	0	-	0	-
9	Тонхил сум	4	18	1,037.2	11	804.9	1	4.6	2	168.7	1	8.6	3	50.5
10	Төгрөг сум	4	11	94.2	6	47.3	2	2.4	1	18.0	0	-	2	26.5
11	Халиун сум	4	13	428.8	9	297.1	0	-	1	73.6	0	-	3	58.2
12	Хөхморьт сум	4	13	833.4	6	480.5	2	4.4	3	300.1	0	-	2	48.4
13	Цогт сум	4	15	1,254.5	9	1,031.0	1	17.6	4	25.5	1	-	0	-
14	Цээл сум	4	6	185.1	3	96.2	1	26.8	1	2.2	0	-	1	60.0
15	Чандмань сум	3	9	231.1	4	175.7	1	10.4	2	21.2	0	-	2	23.8
16	Шарга сум	4	14	208.5	11	167.2			1	1.1	2	1.1	2	40.2
17	Эрдэнэ сум	4	15	1,138.4	11	1,073.5	2	10.4	2	17.4	0	-	2	47.6
18	Гуулин тосгон	1	5	142.4	2	132.1			1	-	0	-	0	-
19	Баянтоорой тосгон	1	3	135.2	1	128.8	1	1.0	3	1,525.6	2	-	2	6.4
20	Есөнбулаг сум	6	17	5,959.0	10	4,416.5	1	69.4	11	542.2	1	-	3	16.0
21	Аймгийн төвийн байгууллагууд	17	52	4,822.6	18	3,880.1	5	69.4	11	542.2	1	-	13	330.9
	НИЙТ ДҮН	92	281	20,057.7	162	15,846.6	26	230.6	42	2,824.0	3	189.1	48	967.4

Хавсралт 4. Орон нутгийн өмчит байгууллагуудын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

ДД	Байгууллагын нэр	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
			сөрөг	татгалзсан	түүвэрт хамрагдсан														
1	Суурин дулаан ОНӨААТҮГ	1				3	552.5	2	552.5									1	-
2	Алтайн тохижилт үйлчилгээний газар" ААТҮГ		1			6	181.4	1	55.1			1	4.0					4	122.3
3	Алтай орон сууцны корпораци ААТҮГ			1		6	431.5	4	393.8	1	37.7							1	-
4	Солонго дулааны станц ААТҮГ		1			9	195.0	4	159.3			3	34.2					2	1.5
5	Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ			1		9	482.2	1	3.6	2	2.2	3	471.5					3	4.9
6	Ундарга-Алтай ААТҮГ			1		13	2,919.2	4	1,232.1	1	4.1	3	219.9	2	0	3		3	1,463.1
7	Гэгээн нуур цэвэр ус ААТҮГ				1														
8	Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв УТҮГ			1		11	606.5	3	540.8			2	23.0	2	0	4		4	42.7
9	Нийтлэг үйлчилгээ УТҮГ	1				1	49.5											1	49.5
10	Орон сууцны алба ОНӨААТҮГ				1	5	598.5	3	28.8			1	471.6					1	98.1
11	Теле камерын хяналтын дэд төв				1	63	6,016.3	22	2,966.0	4	44.0	13	1,224.2	4	0	20		1	1,782.1
НИЙТ ДҮН		2	6		3														